

Компанийн үйл ажиллагаа

PayPal Holding, Inc. нь интернетээр төлбөр дамжуулахад зориулсан үйлчилгээг явуулдаг Америкийн үндэстэн дамнасан компани бөгөөд анх 1998 Confinity нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. 2002 онд IPO зарлан нээлттэй компани болж байсан.

Nasdaq: PYPL

06/20/22

Хаалтын ханш	\$72.90
52 д.х. доод-дээд ханш	\$70.47 - \$310.16
Зах зээлийн үнэлгээ	\$83,912.00 сая
1 өдрийн дундаж арилжаа (ширхэг)	20.23 сая
Нийт хувьцаа (ширхэг)	1,172.00 сая
Үнэ ашгийн харьцаа (P/E)	24.10

Санхүүгийн мэдээлэл

2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн мэдээллээр өмнөх оны мөн үеэс борлуулалтын орлого \$6,483 сая болж 7.5%-аар өссөн боловч цэвэр ашиг \$509 сая болж 56.3%-иар буурчээ. Борлуулалтын өртөг нэмэгдсэн, мөн Apple pay гэх мэт хүчтэй өрсөлдөгчид нэмэгдэж байгаа нь ашиг буурахад нөлөөлжээ.

Хөрөнгө оруулалтын хураангуй

Venmo төлбөрийн үйлчилгээнээс олох орлого 12%-иар өсөх боломжтой. PayPal-ийн Venmo үйлчилгээнээс олсон орлого эхний улиралд 12% өсөж \$58 тэрбум болсон. Amazon энэхүү төлбөрийн үйлчилгээг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр PayPal-ийн онлайн худалдаанаас олох орлого цаашид өсөх томоохон боломж бүрдүүлж байгаа юм.


PayPal-ийн зах зээлийн үнэлгээ он гарснаас хойш 58% унаад байгаа нь хувьцааг ихээхэн хямд болгож байна. Ирээдүйд олох борлуулалтын төсөөллөөс тооцсон үнэ борлуулалтын (P/S) харьцаа 6.20-ны байдлаар 3.19-тэй байгаа нь тус компанийг анх IPO хийснээс хойших хамгийн доод түвшин тул хямд үнээр авах боломжтой харагдаж байна.

Шинжээчдийн таамаглал


Авах	30	Дээд үнэ	\$270.00
Барих	11	Доод үнэ	\$85.00
Зарах	1	Дундаж үнэ	\$153.83
Өсөлтийн%	212%	Одоогийн ханш	\$72.90

Эх сурвалж: Marketbeat.com

PayPal болон Nasdaq индексийн ханш /доллар/



Санхүүгийн үзүүлэлт /сая доллар/



САНАМЖ:

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!